

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЬЕ

Шүлхий нь өвчтэй мал, амьтнаас хүнд халдварладаг вирусний гаралтай цочмог халдварт өвчин юм. Халдварын эх уурхай нь өвчилсөн хүн, мал амьтан.

Халдвар дамжих зам:

1. Өвчтэй малын түүхий сүү, сүүн бүтээгдэхүүн
2. Өвчтэй малыг саах, эмчлэх, арчлах, төхөөрөх үед
3. Агаар дуслын зам /өвчтэй мал амьсгалах ханиалгах/
4. Өвчилсөн малын арьс шир, шээс, баас, шүлс, малын бордоо, өтөг бууц

Өртөмхий бие:

1. Шүлхий өвчин нутагшмал гардаг бүс нутгийн малчид
2. Мах, сүү арьс ширний үйлдвэрлэл эрхлэгчид
3. Мал эмнэлэг болон лабораторийн ажилчид

Илрэх шинж тэмдэг:

1. Гэнэт өндөр халуурах, чичрэх
2. Толгой булчин, ууц нуруугаар өвдөх
3. Хоолонд дургүй болох
4. Амны хөндийн салст хорсч өвдөх
5. Шүлс их хэмжээгээр гоожих
6. Нүд улайх
7. Бөөлжих, суулгах

Урьдчилан сэргийлэх:

1. Хүн мал өвчилсөн тохиолдолд яаралтай мэргэжлийн байгууллагад хандах
2. Малыг өвчлөл гарсан, голомттой газар нутгаас мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн, малын тэжээл, арьс, шир зэргийг зөөвөрлөхгүй байх
3. Голомтын бүс, сэжигтэй бүсийн өвчтэй мал, амьтныг уг бүсийн гадна байгаа эрүүл мал, амьтантай ус бэлчээрээр нийлүүлэхгүй байх
4. Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг бүрэн гүйцэт болгож хэрэглэх
5. Малыг гаралтай бүтээгдэхүүн худалдан авахдаа шинжилгээний болон гарал үүслийн бичгийг шалгах
6. Мэргэжлийн болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бэлчээр нутаг сэлгэхгүй байх
7. Өөрийн эзэмшлийн мал, тэжээвэр амьтдыг мал эмнэлгийн албанаас хийх үзлэг, сэргийлэх тарилга, вакцинжуулалтад бүрэн хамруулах